

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2021/05/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179

Цахим хаяг: nananbayarg@audit.gov.mn

Аудитор: Б.Анхтуяа

Утас: 70543179

Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	18
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Б.ОТГОНЧИМЭГ ТАНАА

2021.08.15 № 01
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар"-ын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хэлтэст мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

000000004

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,635,695.48	66,416,272.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	65,592.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	65,592.00
3121	Төгрөг	00.00	65,592.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	65,592.00
34	УРЬДЧИЛГАА	22,502,000.00	00.00
34200	Төсөвт байгууллага	20,000,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,502,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,133,695.48	66,350,680.08
351	Түүхий эд материал	34,326,700.86	50,441,610.08
35110	Тусгай зориулалттай материал	34,326,700.86	50,441,610.08
354	Хангамжийн материал	10,806,994.62	15,909,070.00
35410	Бичиг хэргийн материал	3,530,970.00	5,125,180.00
35420	Аж ахуйн материал	4,538,824.62	4,683,690.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	763,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,737,200.00	5,337,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	137,900,893.90	258,113,003.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	137,900,893.90	258,113,003.58
392	Биет хөрөнгө	126,838,393.90	247,260,503.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	69,460,463.18	69,460,463.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,356,938.02	-3,796,054.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	79,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-7,768,055.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	187,907,281.16	177,610,759.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-135,742,661.29	-74,384,106.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,919,680.00	11,919,680.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,036,931.18	-7,119,682.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-312,499.95	-562,499.91
393	Биет бус хөрөнгө	11,062,500.00	10,852,500.00
39301	Програм хангамж	1,720,000.00	1,720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,457,500.00	-1,667,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	205,536,589.38	324,529,275.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,033,114.05	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,033,114.05	00.00
413	Өглөг	1,033,114.05	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,033,114.05	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	204,503,475.33	324,529,275.67

51	Засгийн газрын хувь оролцоо	204,503,475.33	324,529,275.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	86,919,521.28	86,919,521.28
51101	Өмч: - төрийн	86,919,521.28	86,919,521.28
512	Хуримтлагдсан үр дүн	113,732,837.45	233,758,637.79
51210	Өмнөх үеийн үр дүн	113,732,837.45	114,763,951.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	118,994,686.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,851,116.60	3,851,116.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	205,536,589.38	324,529,275.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	342,740,541.00	476,396,943.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,330,408.00	98,138,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,330,408.00	98,138,960.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,330,408.00	10,972,459.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,196,508.00	10,507,367.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	465,092.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,133,900.00	87,165,501.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,471,833.00	148,554,083.33
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	205,938,300.00	229,703,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,325,833.00	134,355,763.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,325,833.00	134,355,763.32
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,086,400.00	9,122,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,086,400.00	9,122,600.00
1330	Төсвийн захирагчдаас	7,059,600.00	5,075,720.01
133003	Хөрөнгийн	7,059,600.00	5,075,720.01
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	307,337,940.02	357,402,257.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	307,337,940.02	357,402,257.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,312,592.98	301,427,038.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,099,999.51	171,819,904.12
210101	Үндсэн цалин	148,099,999.51	108,329,745.12
210102	Нэмэгдэл	00.00	47,782,959.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,153,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,553,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,148,119.88	22,740,908.87
210201	Тэтгэврийн даатгал	13,046,836.60	15,702,926.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,675,719.67	1,845,926.80

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,181,857.50	1,386,015.08
210204	Ажилгүйдлийн даатгал	289,064.37	341,003.27
210205	Эрүүл мэндийн даатгал	2,954,641.74	3,465,037.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,298,222.73	7,225,495.54
210301	Гэрэл, цахилгаан	778,660.73	809,313.54
210302	Түлш, халаалт	2,949,562.00	2,949,562.00
210303	Цэвэр, бохир ус	525,000.00	421,620.00
210304	Байрны түрээс	3,045,000.00	3,045,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,209,313.91	24,313,701.91
210401	Бичиг хэрэг	8,671,287.42	7,361,800.79
210402	Тээвэр, шатахуун	6,785,200.00	11,853,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	426,058.00	241,032.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	383,035.00	4,152,318.62
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,954,438.49	00.00
210408	Бараа материал акталсны зардал	2,989,295.00	705,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,564,000.00	3,502,000.00
210604	Урсгал засвар	3,564,000.00	3,502,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,728,300.00	1,044,000.00
210702	Дотоод албан томилолт	1,728,300.00	1,044,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,683,672.50	18,444,836.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,433,672.50	17,432,793.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	65,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	3,043.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,580,964.45	52,336,191.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,580,964.45	52,325,391.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,025,347.04	55,975,218.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,525,000.00	1,237,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,525,000.00	1,237,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,433,517.77	00.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,433,517.77	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	714,377.27	897,104.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	714,377.27	897,104.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,352,452.00	53,841,114.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,352,452.00	11,005,631.01
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	42,835,483.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>35,402,600.99</u>	<u>118,994,686.29</u>

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>35,402,600.99</u>	<u>65,767,741.19</u>
---	--------------------------------	-----------------------------	-----------------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>590,242,001.00</u>	<u>436,840,930.32</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	284,891,468.00	43,658,667.00
120	Нийтлэг татварын бус орлого	284,891,468.00	43,658,667.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	284,891,468.00	43,658,667.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,196,508.00	10,507,367.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	275,694,960.00	33,151,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,350,533.00	393,182,263.32
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	205,938,300.00	229,703,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,325,833.00	154,355,763.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,325,833.00	154,355,763.32
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,086,400.00	9,122,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,086,400.00	9,122,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>580,462,883.00</u>	<u>335,535,338.32</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	580,462,883.00	335,535,338.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,437,535.96	278,492,119.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,098,021.66	171,821,907.80
210101	Үндсэн цалин	92,547,621.66	108,331,748.80
210102	Нэмэгдэл	41,572,200.00	47,782,959.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,110,600.00	4,153,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,867,600.00	11,553,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,148,118.72	22,740,905.19
210201	Тэтгэврийн даатгал	13,634,738.30	15,697,382.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,423,020.13	1,836,368.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	965,679.91	1,390,041.49
210204	Ажилгүйдлийн даатгал	393,840.20	342,011.42
210205	Эрүүл мэндийн даатгал	2,730,840.18	3,475,101.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,298,222.73	7,225,495.54
210301	Гэрэл, цахилгаан	778,660.73	809,313.54
210302	Түлш, халаалт	2,949,562.00	2,949,562.00
210303	Цэвэр, бохир ус	525,000.00	421,620.00
210304	Байрны түрээс	3,045,000.00	3,045,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,258,642.00	13,679,990.00
210401	Бичиг хэрэг	1,016,100.00	1,769,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,695,200.00	10,363,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,505.00	222,090.00

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,216,837.00	1,325,400.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,073,800.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	6,073,800.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,728,300.00	1,044,000.00
210702	Дотоод албан томилолт	1,728,300.00	1,044,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	323,436,430.85	59,883,821.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,491,470.85	26,185,570.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	65,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	3,043.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	275,694,960.00	32,686,208.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,025,347.04	57,043,218.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,525,000.00	2,305,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,525,000.00	2,305,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,433,517.77	00.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,433,517.77	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,714,377.27	897,104.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,714,377.27	897,104.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,352,452.00	53,841,114.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,352,452.00	11,005,631.01
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	42,835,483.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,779,118.00</u>	<u>101,305,592.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,779,118.00	101,240,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,779,118.00	101,240,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,779,118.00	101,240,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,779,118.00	101,240,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-9,779,118.00</u>	<u>-101,240,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	65,592.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	65,592.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,119,521.28	857,146.63	84,029,624.70	00.00	161,006,292.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	66,083,160.00	00.00	66,083,160.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,119,521.28	857,146.63	150,112,784.70	00.00	227,089,452.61
C07	Тайлант үеийн үр дүн	10,800,000.00	00.00	-71,782,548.24	00.00	-60,982,548.24
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	113,732,837.45	00.00	204,503,475.33
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	113,732,837.45	00.00	204,503,475.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,031,114.04	00.00	1,031,114.04
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	114,763,951.50	00.00	205,534,589.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зерүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	118,994,686.29	00.00	118,994,686.29
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	233,758,637.79	00.00	324,529,275.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	220,024,700.00	211,876,804.96	238,826,500.00	237,431,131.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,024,700.00	211,876,804.96	238,826,500.00	237,431,131.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213,497,100.00	205,351,804.96	236,521,300.00	235,126,131.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,030,600.00	148,098,021.66	171,822,000.00	171,821,907.80
210101	Үндсэн цалин	99,480,200.00	92,547,621.66	107,487,800.00	108,331,748.80
210102	Нэмэгдэл	41,572,200.00	41,572,200.00	48,243,800.00	47,782,959.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,110,600.00	3,110,600.00	3,110,600.00	4,153,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,867,600.00	10,867,600.00	12,979,800.00	11,553,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,481,100.00	19,148,118.72	23,211,600.00	22,740,905.19
210201	Тэтгэврийн даатгал	13,464,200.00	13,634,738.30	16,419,400.00	15,697,382.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,504,200.00	1,423,020.13	1,698,000.00	1,836,368.91
210203	ҮОМШО-ний даатгал	1,203,400.00	965,679.91	1,358,300.00	1,390,041.49
210204	Ажилгүйдлийн даатгал	300,700.00	393,840.20	339,600.00	342,011.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,008,600.00	2,730,840.18	3,396,300.00	3,475,101.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,012,600.00	7,298,222.73	8,122,600.00	7,225,495.54
210301	Гэрэл, цахилгаан	1,348,400.00	778,660.73	1,348,400.00	809,313.54
210302	Түлш, халаалт	2,990,000.00	2,949,562.00	3,229,200.00	2,949,562.00
210303	Цэвэр, бохир ус	626,200.00	525,000.00	423,200.00	421,620.00
210304	Байрны түрээс	3,048,000.00	3,045,000.00	3,121,800.00	3,045,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,259,200.00	5,258,642.00	13,505,300.00	13,504,990.00
210401	Бичиг хэрэг	1,016,100.00	1,016,100.00	1,594,500.00	1,594,500.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	10,363,100.00	10,363,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,695,400.00	2,695,200.00	222,300.00	222,090.00
210404	Ном, хэвлэл	222,300.00	330,505.00	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,325,400.00	1,216,837.00	1,325,400.00	1,325,400.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	396,000.00	396,000.00	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,073,800.00	6,073,800.00	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	6,073,800.00	6,073,800.00	1,000,000.00	1,000,000.00

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	1,728,300.00	1,728,300.00	1,048,300.00	1,044,000.00
21070 2	Дотоод албан томилолт	1,728,300.00	1,728,300.00	1,048,300.00	1,044,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,515,500.00	17,350,699.85	16,715,500.00	16,692,833.00
21080 1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,100,700.00	17,100,699.85	15,686,700.00	15,680,790.00
21080 2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	864,000.00	864,000.00
21080 3	Даатгалын үйлчилгээ	65,800.00	00.00	65,800.00	65,800.00
21080 4	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	00.00	79,200.00	79,200.00
21080 5	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	00.00	19,800.00	3,043.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	700000.00	700000.00
21090 1	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	700,000.00	700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6527600.00	6525000.00	2305200.00	2305000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,527,600.00	6,525,000.00	2,305,200.00	2,305,000.00
21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	2,305,200.00	2,305,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	220,024,700.00	211,876,804.96	238,826,500.00	237,431,131.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	205,938,300.00	198,504,782.23	229,703,900.00	229,205,635.99
13100 7	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	205,938,300.00	198,504,782.23	229,703,900.00	229,205,635.99
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,086,400.00	13,372,022.73	9,122,600.00	8,225,495.54
13200 1	Орон нутгийн төсвөөс	14,086,400.00	13,372,022.73	9,122,600.00	8,225,495.54
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	65,592.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	00.00	01.00	01.00
61000 1	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
61000 2	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	14.00	18.00	14.00
62000 1	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
62000 2	Гүйцэтгэх ажилтан	13.00	09.00	13.00	09.00
62000 3	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	03.00	03.00
62000 4	Гэрээт ажилтан	01.00	01.00	01.00	01.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,325,833.00	111,520,280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,325,833.00	111,520,280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,325,833.00	111,520,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал		175,000.00
210401	Бичиг хэрэг		175,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		19,190,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		19,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,325,833.00	92,155,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,325,833.00	92,155,280.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85325833.00	111520280.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85325833.00	111,520,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85325833.00	111,520,280.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Отгончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд зарлагын гүйлгээг цахим бүртгэлийн системээр тулгах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 01-ний хооронд “Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар”-ын аудитор Б.Анхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар”-т 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч, суурь судалгааг үнэн бодит гаргах, цахим хэлбэрт оруулах, бодит мэдээллээр ханган, мэргэжлийн чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх
2. Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажилт тохижилтын ажлыг мөрдүүлэх, барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг тогтмолжуулах, барилгын материалын чанар, барилгын гүйцэтгэлд техник хяналтыг өндөр түвшинд тавих
3. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах
4. Нутаг дэвсгэр дээрх газар, үл хөдлөх хөрөнгийг кадастрын бүртгэлээр баталгаажуулах, мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог сайжруулж хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Барилга хот байгуулалтын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь “Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 03 дугаар улирлын орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 236,538.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,365.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 339,331.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,393.3 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137,063.2 мянган төгрөгөөр буюу 66.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	65.59	65.59
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	22,502.0	0.0	-22,502.0
Бараа материал	45,133.69	66,350.68	21,216.99
Үндсэн хөрөнгө	137,900.89	276,183.55	138,282.66
Нийт хөрөнгө	205,536.58	342,599.82	137,063.25
Өр төлбөр	1,033.11	0.0	-1,033.11
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	204,503.47	342,599.83	138,096.36
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	205,536.58	342,599.83	137,063.25

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 65.6 мянган төгрөг болж өссөн нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдлээс шалтгаалжээ.

Авлaгын данс үлдэгдэлгүй, өөрчлөлт ороогүй бөгөөд урьдчилгаа дансны үлдэгдэл 22,502.00 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн засварын ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, хөлсийг урьдчилж шилжүүлэн засварын ажил хийгдсэн, автомашин худалдан авах тендер шалгаруулалт хүчингүй болсонтой холбоотой үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,350.7 мянган төгрөг болж 21,216.9 мянган төгрөгөөр өссөн нь харьяа дээд шатны байгууллагаас шилжүүлсэн 5,075.7 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 15,580.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 276,183.5 мянган төгрөг болж 138,282.7 мянган төгрөгөөр өссөн нь суудлын автомашин, тоног төхөөрөмж худалдан авсан болон акталсан үндсэн хөрөнгийг дахин үнэлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт буюу техник хяналтын зардлаас 101,240.0 мянга, дахин үнэлсэн 71,297.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын шийдвэрээр 102,934.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,033.1 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Засаг даргын 2020 оны 05/30 тоот “Өглөг барагдуулж ажиллах тухай” захирамжийн хүрээнд ажлын хэсэг томилон, ажлын хэсгийн эзэн холбогдогч тодорхойгүй дүгнэлт, нотлох баримтыг үндэслэн байгууллагын даргын 2020 оны А/29 тоот тушаалаар хуримтлагдсан цалингийн өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 342,599.8 мянган төгрөг болж 138,096.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс шалтгаалжээ.

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 62,358.9 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн болон нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь үндсэн цалин болон барилга захиалагчийн техник хяналтын орлого нэмэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 31,993.7 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ зэрэг зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 1,031.1 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь эзэн холбогдогч тодорхойгүй, дансны бичилтийн алдаанаас үүссэн цалингийн өглөг болохыг ажлын хэсгийн шийдвэр, нотлох баримтад үндэслэн байгууллагын даргын тушаалаар залруулга хийснээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 307,400.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 307,400.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 68,573.8 мянган төгрөгөөр бууруулж, 238,826.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс их хэмжээний бууруулж баталсан нь цалин хөлс, эд хогшил урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71504-Газрын зураглал, кадастр хөтөлбөрийн “80101-үндсэн үйл ажиллагааны зардал”, “80102-туслах үйл ажиллагааны зардал” арга хэмжээг санхүүжүүлэхээр 238,826.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 229,703.9 мянган төгрөгийг улсын төсвөөс 9,122.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 229,703.9 мянга, орон нутгийн төсвөөс 9,122.6 мянга, нийт 238,826.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 237,431.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,395.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 237,431.1 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх НДШ зардлыг 470.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 897.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлыг 22.7 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71504 хөтөлбөрийн 1 арга хэмжээ хэрэгжсэн боловч 1,395.4 мянган төгрөгөөр хэмнэгдэж зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 35,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 53,342.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 152.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Барилгын техник хяналтын орлого	18,500.0	42,835.5	24,335.5	
Эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого	16,500.0	10,507.4	5,992.6	
Нийт дүн	35,000.0	53,342.9	18,342.9	152.4

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж билсэн боловч нэр төрлөөрөө тасарсан байна. Орлогын төлөвлөгөө 152.4 хувиар давсан нь Барилгын техник хяналтын орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Барилгын техник хяналтын орлого 154,180.7 мянга, цахим тендерийн орлого 175.0 мянга, нийт 154,355.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс суудлын автомашин худалдан авах зардалд 79,900.00 мянга, хяналтын ажлын хөлсний зардалд 11,526.1 мянга, барилгын лабораторийн багаж, техник хэрэгслийн зардалд 19,919.1 мянга, бичиг хэргийн материалын зардалд 175.0 мянга, нийт 111,520.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 42,835.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 24,112.3 мянган төгрөгийн зөрчилд 2,946.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 19,866.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1,300.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2,946.1	3	2,946.1	-	-	-
Албан шаардлага	3	19,866.2	3	19,866.2	-	-	-
Зөвлөмж	4	1,300.0	4	1,300.0	-	-	-
Нийт дүн	10	24,112.3	10	24,112.3	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,248.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1,248.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 1 ажилтанд 181.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж залруулсан.
- Эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн 2 удаа мөнгөн урамшуулал олгож, нийт 392.7 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулсан байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
- Цалин, ээлжийн амралт, мөнгөн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой 574.2 мянган төгрөгийн өр, авлага үүсгээгүй байсныг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 100.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 2 алдаа, зөрчил илэрснээс 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг /тухай бүр/ мэдээлээгүй байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 2 алдаа, зөрчил илэрснээс 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг /тухай бүр/ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

“Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын санхүүгийн үйл ажиллагаанд дараах асуудлыг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

1. Барилгын техник хяналтын зардлыг БХБС-ын тушаалаар зарцуулж байгаа боловч нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулж байгаа нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан журамтай зөрчилдөж байна. Иймд барилгын техник хяналтын зардал нь нэмэлт орлого гэж үзэх эсэхийг тодорхой болгож шийдвэрлэх шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүй байна.

1.2. Эрсдэл: Хяналтгүй гүйлгээ хийгдэх, татвараас зайлсхийх

1.3. Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Сангийн сайдын 347 дугаар тушаал, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн дотоод хяналтын журам боловсруулж, хэрэгжүүлэх, татварын цахим бүртгэлийн системээр зарцуулалтыг хянаж байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.05	Аудитын нэр: Говьсүмбэр аймгийн “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ГСА-2021/05/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	1 ажилтанд цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон	181.5	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
2	Эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн 2 удаа мөнгөн урамшуулал олгож, урамшууллыг давхардуулсан.	392.7	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
3	Цалин, ээлжийн амралт, мөнгөн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой өр, авлага үүсгээгүй	574.2	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
4	Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан	100.0	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
5	Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүй	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
6	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг /тухай бүр/ Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй	-	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
ДҮН		1,248.5			

Ахлын баримтын нэр:

Б501

Заглуулаагүй буруу шлэхийг буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл

Ахлын баримтын дугаар:

Аудитын код:

ГСА/2021/05/СТА-ТШЗ

Төгрөгөөр

Аудитын нэр:

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийгдсэн байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Цалин	1	1 ажилтанд цалин, эзлэгийн амралтыг давхардуулан олгосон	181,549.00	Завсрын аудитаар зарлуулга хийх зөвлөмж өгсөн	зөвшөөрсөн	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн		Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
2	Цалин	1	Эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн 2 удаа мөнгөн урамшуулал олгож, урамшууллыг давхардуулсан.	392,699.00	Завсрын аудитаар зарлуулга хийх зөвлөмж өгсөн	зөвшөөрсөн	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн		Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
3	Цалин	1	Цалин, эзлэгийн амралт, мөнгөн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой өр, авлага үүсгэж	574,248.00	Завсрын аудитаар зарлуулга хийх зөвлөмж өгсөн	зөвшөөрсөн	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн		Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
4	Зардал	1	Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан	100,000.00	Зарлуулга хийх	зөвшөөрсөн	Зарлуулга хийгдсэн		Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
5	Зардал	1	Зарлагын гүйлгээг татварын цөхм бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгагүй	-	Зөвлөмж өгөх	зөвшөөрсөн		Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
6	Шилэн данс	1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг гухай бүр/Шилэн дансны цөхм хуудсанд мэдээлээгүй	-	Албан шаардлага өгөх	зөвшөөрсөн		Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Отгончимэг, Л.Туяа
Нийт дүн				1,248,496.00						

Бэлтгэсэн:

Аудитор

/Б.Анхтуяа /

2021.01.29

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

/Г.Наранбаяр /

2021.01.29

Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор

/Б.Сарантуяа /

2021.01.29

Танилцаж зөвшөөрсөн:

Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-ын дарга
Б.Отгончимэг /

Нягтлан бодогч

/Л.Туяа /

2021.01.29

2021.01.29



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01/01

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд автомашин худалдан авах тендер шалгаруулалттай холбоотой Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг /тухай бүр/ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан, 7 дугаар зүйлийн 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг /тухай бүр/ мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

0890000325

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Отгончимэг, нягтлан бодогч Л.Туяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР



Б.АНХТУЯА